


**БАТЛАВ**  
ЗАХИРАЛ  Б.БАЯРМАГНАЙ  
20 ... оны ... сарын ... өдөр  


## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

**Багц-1. Мах, дайвар бүтээгдэхүүнд** худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн гарал үүсэл, шинжилгээний хуудас бүхий бүх төрлийн мах, амьтны мах орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй.

**Багц-2. Үндсэн хүнсний бүтээгдэхүүнд** хуурай болон шингэн сүү, тараг, аарц, **Гурил, гурилан бүтээгдэхүүнд** бялуу, кекс хамаарахгүй, **төмс, хүнсний ногоонд** дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй, **будaa гэдэгт** бүх төрлийн будaa, хүүхдийн будaa, үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна, **жимс, жимсгэнэ гэдэгт** компот, хатаасан жимс хамаарахгүй, **бусад гэдэгт** давс, элсэн чихэр, ургамлын тос, масло, амтлагч, цай, исгэгч орно.

**2. Стандарт:** Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа худалдааны газрын болон нийлүүлэх нэр төрлийн бүтээгдэхүүний тус бүрийн стандарт, мөн бүтээгдэхүүний тээвэрлэлт, сав баглаа боодлын стандартын шаардлага хангасан байна.

**3. Бүтээгдэхүүн нь:** Мэргэжлийн хяналтын газрын үнэлгээ, дүгнэлттэй байх

**4. Байгууллага, аж ахуй нэгж нь:**

- Худалдааны газрын үйлчилгээ MNS 5021:2004 улсын стандартыг мөрдөж хэвшсэн байх
- Үйлчилгээний зориулалтаар зохион байгуулсан худалдааны заалны хэмжээ 41м2-аас багагүй байх
- Шаардлага хангасан хүнсний агуулах, зориулалтын хөргөгч, хөргүүртэй байх
- Үүдний хэсэгт тохижилт, гэрэлтүүлэгтэй энгийн хаяг тавьж зүлэгжүүлсэн байх
- Дэлгүүрийн үүдэнд хог ангилан ялгах сав байршуулсан байх
- Жин хэмжүүр нь баталгаажсан, хугацаа дуусаагүй байх
- Ариун цэвэр, ахуйн хангамжийн өрөө, халаалтын асуудлыг шийдсэн байх
- Худалдаалж буй барааны нэр төрөл олон, сонголт их байх
- Барааны баталгаажилт, шинжилгээний иж бүрдэлтэй байх
- Худалдагч мэргэжлийн, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан эрүүл, ажлын хувцас, энгэрийн тэмдэг, нэрийн хуудсыг зүүж хэвшсэн байх зэрэг шаардлагууд, барааны эргэлт, санхүүгийн чадавх зэргийг харгалзан үзнэ.

- Байнгын татвар төлөгч байх
- НӨАТ-ийн суутган төлөгчөөр бүртгэгдсэн Татварын гэрчилгээтэй, Е баримт хэвлэдэг машинтай байх
- Ажлын байрны үнэлгээтэй байх

#### **4. Баглаа, боодол:**

1. Барааг хэлбэр хэмжээ, жин, ачиж буулгах, тээвэрлэх нөхцөлийг цаг уурт харгалзуулан бат бөх, урагдаж эвдрэхгүй цэвэр нямбай савлаж бэлтгэн нийлүүлэх
2. Нийлүүлэгдэх барааны чанар стандартыг бүрэн хангасан байх, бараа авдаг газрын тодорхойлолт, гарал үүслийн гэрчилгээг хавсаргах
3. Буруу шошигласон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдаалаагүй байх
4. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгонд агуулагдах мэдээлэл монгол, орос, англи хэлний аль нэг дээр бичигдсэн байх
5. Худалдааны газар өөрөө жижиглэн савласан бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл нь шаардлага хангасан байх
6. Хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байх
7. Зарим нэр төрлийн барааг хоёрдогч гуравдагч этгээдээс авч нийлүүлж байгаа бол хамтралын гэрээний хуулбарыг хавсаргах]

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН: ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО